

МОНГОЛ УЛСЫН САЛГИЙН САЙДЫН ТУШААЛ,
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЦАРГЫН ЗАХИРАМЕ

1994 оны 02 сарын
21 ны өдөр

Дугаар 39/А-85

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 1993 оны 194 дүгээр тогтоолын I-ийн "а" заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын татварын ерөнхий газрын харьяа Татвар, хяналтын газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Татвар, хяналтын газартай харилцах замаар нийслэлийн төсөвт татвар төлөх аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Гадаацын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн орлого, татварт хяналт тавих, төсөвт цуглуулж оруулах үүргийг 1994 оны 2 дугаар сарын I-нээс эхлэн Татвар, хяналтын газарт хариуцуулсугай.

4. Нийслэлийн төсөвт орлого төлдөг хавсралт 2-т заасан аж ахуйн нэгжүүдээс орлого бүрдүүлэх, тэдгээрт татварын хяналт явуулах ажлыг Татвар, хяналтын газраар гүйцэтгүүлсэн ажлын дүнг 1995 оны I улиралд гаргав зохих дүгнэлт хийх үндсэн дээр Нийслэлийн төсөвтэй харьцааг аж ахуйн нэгжийн орлого, татварын цуглуулалт, хяналт шалгалтыг цаашид татвар, хяналтын газарт хамааруулах эсэхийг эцэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсүгэй.



Д.ДАВААСМБУУ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ЦАРГА

Ц.БААСАНЖАВ

Хаворалт № I.

Сангийн сайдын 1994 оны 39 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын 42 тоот захирамжаар батлав.

**УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАЯЬЛА
ТАТВАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН ТҮР ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Татвар хяналтын газрын /цаашид газар гэнэ/ үндсэн зорилт нь Монгол улсын татварын хуулиудыг хэрэгжүүлэх, улсын төвлөрсөн төсвийн орлогыг Монгол улсын Их Хурлаас, нийслэлийн төсвийн орлогыг Нийслэлийн хурлын тэргүүлэгчдийн хурлаас тус баталсан хэмжээгээр бүрдүүлэх, харилцагч аж ахуйн нэгж байгууллагад татварын хяналт шалгалт хийх явдал мөн.

2. Газар нь Монгол улсын татварын ерөнхий хууль болон Монгол улсын албан татварын бусад хуулиуд, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хууль, Сангийн сайд, Улсын татварын ерөнхий газраас баталсан дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

3. Газрын зохион байгуулалт, эрх үүрэг энэ дүрмээр зохицуулагдана.

4. Газар нь бие даасан төсөвтэй байх бөгөөд санхүүжилтээ Улсын татварын ерөнхий газраас авч байна.

5. Газраас Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг харилцагч татвар төлөгчид хэрэгжүүлнэ.

Хоёр. Зохион байгуулалт

6. Газар нь Улсын татварын ерөнхий газрын харьяанд байна.

Газар нь харуцах ажлын чиглэлээр хэлтсүхдтэй байна. Хэлтсүүд нь төвлөрсөн төсөв болон нийслэлийн төсвийн орлогыг төлөвлөх, бүрдүүлэх, үүнтэй холбогдоон судалгаа тооцоо хийх, харилцагч татвар төлөгчдийн үйл ажиллагаанд татварын хяналт шалгалт явуулах, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээр зохион байгуулагдана. Ингэх дээ төвлөрсөн төсвийн орлого, нийслэлийн төсвийн орлого нь хоорондоо холилдохгүйгээр зохих давсад аль болох богино хугацаанд орохоор зохион байгуулагдсан байна.

8. Газар нь харилцагч аж ахуйн нэгж байгууллагаас төвлөрсөн болон Нийслэлийн төсөвт төлбөл зохих орлогыг хуулийн дагуу бүрэн оруулах үүрэгтэй бөгөөд энэ талаар Сангийн яам, Улсын татварын ерөнхий газар Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцлага хүлээнэ.

9. Газрыг Улсын татварын ерөнхий газрын дэд дарга бөгөөд газрын дарга толгойлно. Газрын даргыг Монгол улсын Сангийн сайд томилж буюу чөлөөлнө.

10. Газар нь орлогч даргатай байж болно.

11. Газрын эрхлэх ажил үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн байхын тулд газрын зөвлөл ажиллуулж болно.

12. Газар нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, албан ёвчгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

13. Татварын хэрэг бүртгэлийг улсын татварын ерөнхий газар болон нийслэлийн татварын газрын хэрэг бүртгэх нэгжид шилжүүлэн гүйцэтгүүлнэ.

Гурав. Татвар хяналтын газрын үүрэг, эрх

14. Татвар хяналтын газар нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/ төвлөрсөн төсөв болон нийслэлийн төсвийн орлогыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах, татварын хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих;

б/ харилцагч аж ахуйн нэгж байгууллага нь татварын орлогын оногдуулалт, төлөлтийн тайланг тогтоосон хугацаанд нь гаргуулан авч тооцоо хийх;

в/ төвлөрсөн төсөв болон нийслэлийн төсөвт татвар төлөгчид татварын хууль, тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авах;

г/ Аж ахуйн нэгж байгууллагуудад татварын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хэрхэн явагдаж байгаа талаар сурталчилгаа хийх, ажил төрлийн семинар, уулзалт зохион байгуулах;

д/ гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, тэдгээрт татварын хяналт үзүүлэх, чөлөөлөх асуудлыг мөрдөж байгаа хууль, дүрэм журмын хүрээнд шийдэх;

е/татварын улсын болон дотоод мэдээ, тайланг Улсын татварын ерөнхий газарт тогтоосон хугацаанд нь гарган өгч байх;

ж/газрыг үнэнч шударга, саяхуу, татвар, бүртгэлийн ажлын мэдлэг туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх;

з/газар нь аж ахуйн нэгж байгууллагад татварын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон мэдээ, мэдээллийг Нийслэлийн болон дүүрэг аймаг, хотын татварын албадаас явах буюу өгөх.

16.Татвар, хяналтын газар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ.

а/Монгол улсын татварын албаны дүрмийн 17 дугаар зүйлийн б,г,д,е,ж,к,л,м,н-д заасан заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж хэрэг жүүлэх;

б/эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал шийдвэр гаргах;

в/газрын байцаагчийн тавьсан актыг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг цуцлах.

Саягын сайдны 1994 оны 32
 тоот тушаал, Ийнсталийн Засаг
 даргын 1994 оны 2-д тоот
 захирэмжийн 2-р хавсралт

ТАТВАР, ХЯНГАЛТЫН ГАЗАРТАЙ ХАРАЛНАХ
 ЗАМААР ӨНДӨЛӨГӨЙН ТӨСӨӨТ ОРЛОГО
 ӨРӨГДӨХ АЖ АХУЙН НЭГЖИЙН МАГСААЛТ

Н /д/	Аж ахуйн нэгжийн нэр	1994 оны орлого /мян.төг/
1.	Монгол газрын тос компани	661.0 .
2.	Нуурс компани /УУГ/	8339.7 .
3.	Шороон орд компани	218.3 .
4.	Эрчим импекс компани	13797.0 .
5.	Бага нуурын нүүрсний уурхай	1727087.2 .
6.	Зоос гоёлын зүйлийн үйлдвэр	157718.5 .
7.	Их Зашир алтны орд	-
8.	Монгол ноос /ХК/	69242.5 .
9.	Сүлдэр ХК	31509.0 .
10.	Ээрмэлийн үйлдвэрийн түрээсийн цех	1247.8 .
11.	Монгол хивс /ББХК/	4870.3 .
12.	Ээрмэл /ХК/	79983.5 .
13.	Савхин гутлын үйлдвэр	170750.0 .
14.	Чанбай /ХК/ Савхин яашиг эдлэл/	24921.0 .
15.	Шевроны үйлдвэр	28777.0 .
16.	Нэхээсгүй эдлэлийн үйлдвэр	8907.5 .
17.	Мах импекс ХК	91597.0 .
18.	Талх няхэр компани	444678.8 .
19.	Сүү компани	136699.9 .
20.	Монгол электрон фирм	3099.4 .